

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД
ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ**

2025 оны 06 дугаар сарын 03

№	Санал өгсөн байгууллага, иргэн	Санал	Саналыг тусгасан байдал
2025.01.22-ны өдөр /Судалгааны дэд ажлын хэсгийн хэлэлцүүлэг/			
	М.Нямдорж МУБИС-ын НАТ-ийн багш	- Хуулийн нэр томъёог сайтар нягтлах - Нийгмийн ажилтан гэх үү, халамжийн нийгмийн ажилтан гэх үү, мэргэжилтэн гэхүү нэр томъёог нэг талд нь гаргаж цэгцлэх шаардлагатай.	-Саналын тусгаж сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн гэж өөрчилсөн.
	П.Батжаргал ГБХНХЯ-ны ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн	- Баян-Өлгий аймгийн сум, багийн дэргэд байгуулагдсан Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааг анхаарах - Урамшууллыг хассан	-Саналыг тусгаж, Амьжиргааг дэмжих зөвлөлийг хуулийн төслөөс хассан.
	Д.Энхтуул СХД-ийн ХХҮХ-ийн дарга	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн бол нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг болгох.	-Нийгмийн даатгалын холбогдох удирдлагуудад уламжилж, хуулийн төсөлдөө тусгуулах санал өгсөн.
2025.01.29-ны өдөр /Хөгжлийн бэрхшээлтэй иргэний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд/			
1.	Энхчимэг: Эрхэм нандин сувд ТББ	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох халамжийн дэмжлэгийг амьжиргаагаар уялдуулах асуудлыг судлах - Унаагаар үйлчлэх. Өдрийн үйлчилгээ, дэмжих үйлчилгээг оруулах. - Зуслангийн хөнгөлөлт 100% болгож, хүүхэдтэй хамт амрах эцэг, эхийн зардлыг 50% хөнгөлөх - Аарцаг эрхтэн ... хүүхэд, иргэн гэж ялгалгүй хөгжлийн бэрхшээлтэй хүнд живхний хөнгөлөлтийг олгох хэрэгтэй.	-Саналыг тусгаж, ялгаатай хэрэгцээнд үндэслэж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ тогтоох, үйлчилгээний нэр төрлийг нэмэх заалтууд хуулийн төсөлд тусгасан. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 26.1.5-д Дэмжих төв гэж нэмсэн. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 26.1.16-д “живхний үнийн хөнгөлөлт” гэж нэмсэн
2.	Туяажаргал:	- Олон нийтийн оролцоог түшиглэсэн	- Саналыг тусгаж Хөгжлийн бэрхшээлтэй

	Эрхэм нандин сувд ТББ	халамжийн үйлчилгээг сайжруулах хэрэгтэй - Сувиллын хөнгөлөлтийг сувилалд яваад ирсний дараа олгодгийг өөрчлөх - Зуслан: ХБХүүхэд ганцаар зусланд явах боломжгүй тул асран хамгаалагчийн зардлыг хөнгөлөх. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгэмшүүлэхэд хэрэгтэй халамжийн үйлчилгээнүүдийн нэг. - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд урт хугацааны сэргээн засах үйлчилгээ чухал байгаа, яамд дундаа орхих вий гэдэг дээр анхараах	хүний эрхийн тухай хуульд үйлчилгээний нэр төрлийг нэмсэн. - Саналыг тусгаж, сувиллын газарт төлбөрийг ЭМД-санд шилжүүлж, иргэний хөнгөлөлтийг үйлчилгээ авахаас өмнө тусгасан. - Зусланд хөнгөлөлтийг 100 хувь болгохоор нэмсэн. Харин хүүхдийнх тул асран хамгаалагч нэмэх нь зуслангийн стандартад нийцэхгүй юм. Харин туслах багшийн орон тоог нэмэх асуудлыг судлах, холбогдох байгууллагад уламжлах - Хөгжлийн бэрхшээлтэй хүнд урт хугацааны сэргээн засах үйлчилгээ үзүүлэхээр эрүүл мэндийн болон ХБ хүний бусад хуульд өөрчлөлт оруулахаар тусгасан.
3.	Алтанзагас /Хөдөлмөрийн бэрхшээлтэй иргэн ажилчдын холбоо-танхим/	- Харлилцаа холбоо зардал /10 кг/ - Журмыг нэг ойлголттой хэрэгжүүлдэг болгох, дүүргүүд өөр өөрөөр хэрэгжүүлээд байна.	Саналыг тусгаж бусад үйлчилгээнд нэгтгэсэн. Саналыг авч, сургалт зөвлөмжийг өгч байгаа.
4.	Мөнхцэцэг /Дундговь хараагүйчүүдийн холбоо/	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн өндөр настнууд, зорилтот иргэндээ халамжийн үйлчилгээ хүрэхгүй байна. - Бүрэн харааны бэрхшээлтэй 3 хүн хасагдсан байна.	Хэрэгжилттэй холбоотой заалтууд тул харъяа газруудад чиглэл өгсөн.
5.	Ц.Алтантуул /Сонсголын бэрхшээлтэй эцэг эхчүүд/:	- 1 дүгээр ангид орсон хүүхэд 7 дугаар ангидаа суралцахуйн бэрхшээлтэй болсон ба сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй болсон - Дохионы хэлмэрчийн асуудлыг хуульд тусгах - Тэмдэглэл хөтлөгчийн цалингийн асуудлыг шийдэх - Дүнгийн суулгац 53,0сая төгрөг төрөөс өгдөг ч хүнд хүүхдэд сонсгол оруулах боломж муу байдаг.	Хүүхдийн боловсролын чанарын асуудлыг холбогдох яаманд уламжилсан. Дохионы хэлний тухай хуулийн төсөл боловсруулж байна. Дүнгийн суулгацын хагалгааны зардлыг нэмэхийн тулд Нийгмийн халамжийн сангаас олгодог протез, ортопед, тусгай хэрэгслийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэхээр дагалдаж гарах хуулийн төслүүдэд тусгасан.

6.	Уянга ХБХЭЭХолбоо ТББ	- Хүүхдийн нас 18 хүртэл гэж хуулинд оруулах, нийцүүлэх - Рашаанаас Олон нийтийн оролцоог түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам хэрэгждэггүй. - Тэжээгчээ алдсаны тэтгэмжийг амьжиргааны түвшинтэй уялдуулахгүй олгох. - Хариуцлагын тогтолцоо яаж орж байгаа вэ	Саналыг тусгасан. Журмыг шинэчилсэн. Хэмжээг ялгаатай байхаар тусгасан. Хариуцлагын асуудлыг тусгасан.
7.	Оюунцэцэг /Эрхэм чанар/:	- Протез үйлчилгээ нэмэх хэрэгтэй - Тэргэнцэр үйлчилгээ бага байна - Эрээний тэргэнцэр хасах хэрэгтэй - Таяг 20,0 болих хэрэгтэй - Цооролтын гудас оруулах - Хувийн туслах асаргаа хэрэгтэй	Саналыг тусгасан. Нийгмийн халамжийн сангаас олгодог протез, ортопед, тусгай хэрэгслийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, Эрүүл мэндийн даатгалаас нэн шаардлагатай цооролтын гудас, протезийн үнийг олгох юм. Хувийн туслах болон асрагааны хувилбарт үйлчилгээг хуулийн төсөлд нэмж тусгасан.
8.	Элбэгдорж /ХБХЭЭХолбоо/:	- Байнгын асаргаа шаардлагатай тэтгэмжийг ялгах хэрэгтэй - Насан туршдаа хэвтрийн байгаа хүний асаргааг ялгах хэрэгтэй - Хөгжлийн төв. Оршин суугаа орон нутагтаа яаж үйлчилгээ авахыг оруулах - Олон нийтэд түшиглэсэн хяналт, хэрэгжилт сайн байх	Саналыг тусгаж, ялгаатай хэрэгцээнд үндэслэж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ тогтоох, үйлчилгээний нэр төрлийг нэмэх заалтууд хуулийн төсөлд тусгасан.
9.	Мөнхжаргал /Түгээмэл хөгжил/:	- Байнгын асаргаа шаардлагатай тэтгэмжийг, хувийн туслах үйлчилгээний аль нэгийг авна. - Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуультай нийцэж байна. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүжүүлэх нь зөв - Амралт, рашаан сувилал хүртээмжтэй болгох - Цооролтын гудас бас чухал	-Хувийн туслах үйлчилгээ нь Хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүждэг. Байнгын асаргаа шаардлагатай тэтгэмжийг, хувийн туслах үйлчилгээтэй давхардуулан олгохгүй байхаар нийгмийн халамжийн тухай хуулийн дагалдах хуулийн төсөлд тусгасан. -Хуулийн шинэчлэлээр хөгжлийн бэрхшээлтэй хүний сувилуулах, сувиллын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх өөрчлөлт оруулсан.

			- Нийгмийн халамжийн сангаас олгодог протез, ортопед, тусгай хэрэгслийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, Эрүүл мэндийн даатгалаас нэн шаардлагатай цооролтын гудас, протезийн үнийг олгох юм.
10.	Лхагваа/ Өвөрхангай/:	- 25 ажилтанд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх заалт өөрчлөгдсөн үү, аймагт 25 ажилтантай компани цөөн байдаг - Хөдөлмөрийн чадвараа 80% алдсан хүнд олгох түлшний хөнгөлөлт 140,000 төгрөг бага байна.	Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулж байна. -Түлээ нүүрсний хөнгөлөлтийг амьжиргааны түвшинтэй уялдуулах, эрхийн бичгээр олгох зохицуулалт хуулийн төсөлд тусгасан.
11.	Баатаржав /ХБИНХ/:	- Халамжийг бэлэн мөнгөнөөс хол болгох - 1, 2 дугаар зэрэг, ваучер...гэх мэт Бэлэн мөнгө өгөөд байхаар олон сөрөг үр дагавартай байна - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний архи тамхинд донтсон иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмжийг хасах..	-Хувийн хэвшил, орон нутгийн оролцоотой халамжийн шинэ төрлийн үйлчилгээг бий болгох, бэлэн мөнгөөр биш эрхийн бичиг хэлбэрээр хэрэгжүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. -Халамжийн хуулийн төсөлд архинд донтсон иргэдтэй ажиллах нөлөөллийн ажлыг тусгайлан тусгасан.
12.	Болороо /ГБХНХЯ/	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн хуулийн шинэчилсэн найруулгаар хөнгөлийн бэрхшээлтэй хүнд олгох хөнгөлөлт, тусламжийг халамжийн тухай хуульд оруулбал яасан юм бэ? - 1000+, 500 км+ гэж оруулж болох уу? - Зусланд 100%, асран хамгаалагч 50%, унааны зардлыг нэмж, 10кг шуудан илгээмжийг хасахаар хуулийн төсөлд тусгах	-Хөнгөлөлт, тусламж нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай бие даасан хуулиар зохицуулагддаг. -Зусланд хөнгөлөлтийг 100 хувь болгохоор нэмсэн. Харин хүүхдийнх тул асран хамгаалагч нэмэх нь зуслангийн стандартад нийцэхгүй юм. Сувиллын тухайд зөвхөн рашаан сувилалд сувилуулахаар байсныг магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилал гэж өөрчлөн хүртээмжийг нэмэгдүүлсэн бөгөөд унааны зардлыг олгохоор дагаж гарах хуулийн төсөлд тусгасан. -Харилцаа холбааны зардлыг тэтгэвэртэй нэгтгэсэн.
2025.01.29-ний өдөр Аймаг дүүргийн ХХҮХ/албадын дарга нарын хэлэлцүүлэг			

1.	Хонгорзул /Хэнтий аймгийн ХХҮГ-ын дарга/	- Онцгой- 1.2 сая төгрөгийг нэмэх - протез, ортопед үнийн хөнгөлөлтийг нэмэх - Ахмадын шинэ төрлийн үйлчилгээг нэмтрүүлэх	Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ үзүүлэхээр хуулийн хуулийн төсөлд зүйл нэмж тусгасан - Нийгмийн халамжийн сангаас олгодог протез, ортопед, тусгай хэрэгслийн зардлыг Эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлж, эмнэлгийн хэрэглэгдэхүүнээр, олгох журмыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл батлахаар хуулийн төсөлд тусгасан.
2.	Долгормаа /Дорноговь аймгийн ХХҮГ-ын дарга/	- Амьжиргааны эх үүсвэрээ алдсан талаар мэдээллийн сан үүсгэх - Нийгмийн баталгааны санал - Амьжиргаа дэмжих зөвлөл байх шаардлагатай	- Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ үзүүлэхээр хуулийн хуулийн төсөлд зүйл нэмж тусгасан. - Сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтний цалин хөлс, мэргэшлийн зэрэг, урамшуулал зэргийг зохицуулах талаар хуулийн төсөлд тусгасан. -Амьжиргаа дэмжих зөвлөлийг хуулийн төслөөс хассан.
3.	Нямдэмбэрэл /Завхан/:	- Асаргааны тэтгэмж дээр өвчний оношийг зааж өгөх эрүүл мэндийн байгууллагад шилжүүлэх - Хорт хавдарын 4 дүгээр шат эдгэсэн тохиолдолд халамжаас гарахгүй байх сонирхол байгаа тул нарийн зохицуулах	-Хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа болон байнгын асаргаа шаардлагатай эсэхийг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл тогтоохоор хуулийн төсөлд тусгав.
4.	Сэлэнгэ /Баярмаа/	- Эрүүл мэндийн магадлалын зөвлөл асаргаа тогтоох нь зөв - Байнгын асаргаа шаардлагатай хяналтын зардал тавьж болох уу - Протез ортопедийн хөнгөлөлийг ахмадуудад нэхэмжлэхээр, бэлэн мөнгөөр олгодог сонголттой болгох	-Хуулийн төсөлд протез, ортопедийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын байгууллага руу шилжүүлэхээр тусгасан. Халамжийн хөтөлбөрүүдийн хяналт, шалгалтын зардлыг тухайн хуулийн төслийн 22.1.9-д “нийгмийн халамжийн бодлого, үр нөлөө, үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ, хяналт, үнэлгээ хийх;” гэж оруулсан.
5.	Саранчимэг /Багахангай/:	- Нүүрсний 140,000 төгрөг нэмэгдүүлэх, тэтгэвэр дээр нэмж олгоно гэхээр гайхаад байна - Амьжиргаатай зарим үйлчилгээг	-Хуулийн төсөлд түлшний үнийн хөнгөлөлтийг амьжиргааны түвшний үнэлгээтэй уялдуулан олгох, орон нутаг нь хариуцан хэрэгжүүлэх, орон нутгийн төсвөөс

		уялдуулж болохгүй байна Хүнсний эрхийн бичиг авдаг өрх 475 оноотой үнэлэгдсэн - 18-24 насны иргэдийн үйлчилгээг амьжиргаатай уялдуулахгүй байх - Байнгын асаргаа шаардлагатай буруу тогтоосон эмчид хариуцлага тооцдог байх - Асаргааны хувилбарт үйлчилгээнд - Кейсменежмент дэмжиж байна - Хараагүй- Брайль хасах - ОНОТХҮ үзүүлэх байгууллага байхгүй	олгох зохицууллалтыг тусгасан. -Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийн шинэчлэл, мэдээлэлд үндэслэн халамжийн арга хэмжээг амьжиргааны түвшинтэй уялдуулан үзүүлэхээр төсөлд тусгасан. -Эмнэлэг хяналтын комисс, эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлагын асуудлыг дагалдаж өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгасан.
6.	Эрдэнэдалай /Дундговь/- Нийгмийн ажилтан	- Хавдрын 3,4 дүгээр шатандаа байгаа үнэлгээний шалгуурыг янзлах асаргааны үнэлгээ	-Эрүүл мэндийн болон Нийгмийн халамжий асуудал хариуцсан сайдын хамтарсан тушалаар баталсан журам, шалгуурт өөрчлөлт оруулах, судлах шаардлагатай.
7.	Дундговь:	- Байнгын асаргаа шаардлагатай хөнгөлөлттэй асаргаа тогтоох асуудлыг мэдээлэлтэй болгох - Асаргаа Эрүүл мэндийн магадлалын зөвлөл тогтоох онош зөрдөг.	-Байнгын асаргаа шаардлагатай ахмад настны тэтгэмж нь тухайн хүний өвчин, гэмтэл, эрүүл мэндийн байдал, бие даах чадварт үндэслэн түүнийг асран хамгаалагчид олгож байгаа тэтгэмж бөгөөд тухайн өрхийн амьжиргааны түвшний үнэлгээтэй уялдуулан ялгаатай байхаар төсөлд тусгасан. -Хуулийн төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа болон байнгын асаргаа шаардлагатай эсэхийг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл хамт тогтоох нь иргэдэд хүндрэлгүй байхаар тусгав.
8.	Дэлгэрмөрөн /Хөвсгөл/:	- Нийгмийн даатгалын 11 дүгээр зүйлд: 36 сар төлсөн тохиолдолд тэтгэвэрт орохгүй байна - Цаатан иргэдийн тэтгэмж Хуульд оруулах, амьжиргааны түвшинтэй уялдуулахаар зардал их ороод байна. - АДЗ-г байх шаардлагатай	-Саналыг судлан үзэж Нийгмийн даатгалын холбогдох хууль тогтоомжид тусгах асуудлаар ярилцах шаардлагатай. -Цаатны тэтгэмжийн тухайд МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжиж байгаа арга хэмжээ юм. -Хуулийн төслөөс Амьжиргааг дэмжих зөвлөлийг хассан.

9.	Баярхүү /Багануур/:	- Тэжээн тэтгэх үр хүүхэдгүй бол ахмадын асаргаа өгч байвал ямар вэ, аав ээжийгээ асрах ёстой тул хүүхдэд хүнд асаргаа өгөхгүй байх	Байнгын асаргаа шаардлагатай ахмад настны тэтгэмж нь тухайн хүний өвчин, гэмтэл, эрүүл мэндийн байдал, бие даах чадварт үндэслэн түүнийг асран хамгаалагчид олгож байгаа тэтгэмж бөгөөд тухайн өрхийн амьжиргааны түвшний үнэлгээтэй уялдуулан ялгаатай байхаар төсөлд тусгасан.
10.	Хишигдаваа /Дундговь/:	- Төрсөн хүүхэд асарч байгаа бол амьжиргааны түвшинтэй уявал зүгээр Эмчийг хянах санаатай байна 2лаа асаргаатай 2 ахмад нэгнээ асарна хуульд оруулах	Саналыг тусгав. -Эх, хүүхдэд олгож байгаа тэтгэмжүүд Гэр бүлийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгтгэгдэж орсон. Ахмад настны асаргааны тэтгэмжийг хуулийн төсөлд тусгасан.
11.	Эрдэнэбат /Орхон/:	- Асаргааг эрүүл мэндийн байгууллагад шилжүүлбэл ямар вэ - Одонтой эхийг халамжаас хасах	-Хуулийн төсөлд байнгын асаргааны тэтгэмжийг нийгмийн халамжийн тэтгэмжийн нэг төрөл хэвээр үлдээсэн, харин асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох асуудлыг иргэдэд чирэгдэлгүй болгох, тодорхойлж байгаа ЭХК-ийн хариуцлагын асуудлыг дагалдах хуулиудад тусгасан. -Гэр бүлийг дэмжих тухай хуулиаар зохицуулахаар хуулийн төсөлд тусгасан.
2025.02.04 Олон улсын байгууллагатай хийсэн хэлэлцүүлэг			
1.	Н.Монголмаа, Дэлхийн банк	- Халамийн сан, - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн уялдааг харах - Hybrid аргаар тулгалт хийж, өрхийн мэдээлийн санг сайжруулах - Targeting огт хасахгүй гэсэн санаа яваад байна. Шаталсан хэлбэрт өгвөл давхцал байсаар байна. - Халамж- тэтгэвэр Нийгмийн даатгалтай сайн ... насны хишиг насны ... зэргийг нийтлэг том зургаар хараач, зарчмаар нь уях, хөдөлмөрийн хөлстэй уях уу? гэдэг бол зарчимд	-Холбогдох саналуудыг судлан үзэж, Нийгмийнхаламжийн тухай хуулийн төсөл болон дагалдаж өөрчлөлт оруулах хуулийн төслүүдэд тусгасан болно.

		тохирох амьжиргаагаа сайн барих - Тэтгэмж алдах эрсдэлтэй байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт- энийг яаж зохицуулах - Тогтвортой ажилтай болох хүртэл тэтгэмжийг олгож байх - Хуулийг салгачихаар адилхан нийгмийн халамжийн зардалд орно. - Дэлхийн банк зардал их байна өртөг ихтэй зорилтот бүлэгт сайн хүрэх - ЗМС-с hybridруу шилжиж байгаа дундаж амьжиргааатай хэсгээ ... хэрэгтэй	
2.	Энхцэцэг /ADB/:	- Хуульд өсөлт их байгаа, сайн бэлдэх, нөлөө, сайн хамгаалах хэрэгтэй Халамж-хөдөлмөртэй сайн уях хэрэгтэй м/сангаа яаж бүрдүүлж, яаж хэрэглэх сайн ярих хэрэгтэй - Нийгмийн ажилтан хуульд нэг нэршилтэй болгох ТЗ гээд нийгмийн ажилтаны үйлчилгээг хүргэдэггүй - Асаргааны сургалт хэрэгжихгүй байгаа тул ТБ5-р хэрэгжүүлэх - Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын гэдгийг бодох хэрэгтэй - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ХЭД зөрчилддөг	-Саналын тусгаж сум, хорооны нийгмийн халамжийн мэргэжилтэн гэж хуулийн төсөлд өөрчилсөн. -Асаргааны сургалтын тухайд хуулийн төслийн 8.11-д “Энэ хуулийн 8.1.1, 8.1.2-т заасан иргэнд асаргаа, сувилгаа, сэтгэл зүй болон хүний эрхийн сургалтыг аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь иргэн, хуулийн этгээдээр гэрээлэн гүйцэтгүүлж, зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.”, 8.13-т “Энэ хуулийн 8.11, 8.12-т заасан сургалтын хөтөлбөр болон зохион байгуулах, гэрээлэн гүйцэтгэх иргэн, хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж тусгасан. -Мөн хуулийн төсөлд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ болон зарим хөтөлбөрийн (хүнс тэжээлийндэмжлэг) нөхцөл шалгуурт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлийг тусгаж оруулсан.
3.	Ц. Болормаа /ADB/:	- ОНОТХҮ шалгуур заавраа баталсан гэж ойлгож байгаа хэрэгжүүлэх маш нарийн	-Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний журмууд шинэчлэгдэн батлагдаж хэрэгжиж байгаа.

		зохицуулалттай Агентлаг бэлтгэгдсэн байна вэ	Хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Нийгмийн халамжийн үйлчилгээ”-ний төрөлд 16.1.Нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна: 16.1.1.бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээ; 16.1.2.асрамжийн үйлчилгээ; 16.1.3.гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээ тусгагдсан.
4.	Мөнхтуул /НҮБ-Хүүхдийн сан/:	- Дахин харж байж санал өгье - Гэр бүлийг дэмжих хууль явж байна юм үлдэх вий - Давхардаад 2 АДТ-д хүрэхгүй байх асуудал байна - Өмнөх үзүүлэлтээр авахаар зарим тохиолдолд хэцүү байна - 2 хуулиа зэрэг харах	Саналыг тусгав. -Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл, Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хуулийн давхцал, хийдлийг тулгаж нягталсан болно.
5.	Алтантулга /JICA/:	- Ойрын хугацаанд батлуулах - ХАХ-д яаж туссан - Хуулийн төлөө үзээд санал өгнө - Хүртээмжтэй, хүрэлцээтэй байх - Процесс ... тусгавал хэрэгжилт ... байна. - Нөхцөл тавихдаа болгоомтой байх - Эрүүл мэндтэй холбоотой үйлчилгээг эрүүл мэндрүү өгвөл яасан юм бэ, нийгмийн ажилтан үүнийг мэдэхгүй - Хасах тэтгэмжийг зоригтой хасах - Аргагчлалаа шинэчлэхдээ анхаарах - уялдаатай байх дунд дээд түвшинд үзүүлэх үйлчилгээ - ХЭДС зөв үйлчилгээтэй байх хэрэгтэй - Нийгмийн даатгал болон бусад хуультай уялдуулах	Саналыг тусгав. -Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний протез, ортопед, тусгай хэрэгслийн хөнгөлөлт, сувиллын хөнгөлөлт зэргийг дагалдах хуулийн төслүүдэд мэргэжлийн байгууллага буюу эрүүл мэндийн үйлчилгээ рүү шилжүүлэхээр тусгасан. -Амьжиргааны түвшний оноотой уялдуулж үзүүлэх үйлчилгээ, хэрэгжүүлэх журмуудад нарийвчлан тусгах боломжтой, Хуулийн төслийг боловсруулахад дагалдах хуулиудын нэмэлт, өөрчлөлт, уялдаа холбоо, давхардлыг судлан боловсруулсан.
6.	Гантулга /МУЗН/:	- Дотоодын шилжин суурьшигчийн асуудал тусгасан эсэх	-Хуулийн төсөлд заасан бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээ болон гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээнд шилжин суурьшсан зорилтот

			бүлгийн иргэдийг хамруулах, холбогдох журмуудад тусгах боломжтой.
7.	Болормаа /ILO/:	- Иргэн, гадаадын иргэн харьяалалгүй хүнийг яах вэ. Жишээ нь: албадан хөдөлмөрт өртсөн гадаадын иргэн байна. - Олон улсын байгууллага шахалт уу, урьдчилан сэргийлэх нь чухал 3 сараас өөр юм алга тэтгэвэр, тэтгэмж хэвтээ босоо тэлэлт байгаа юу? - Бүх нийтийн .. баталгааг хангахын тулд 3 хуулиа зэрэгцүүлж үзээд орхигдуулахгүй байх - 1 хүнд очих тэтгэмжийг хасахаас илүү ммьжиргааны доод түвшинтэй харьцуулж харах	-Хуулийн төсөл, дагалдах хуулийн үйлчлэлд хуулийн хамрах хүрээнд Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн халамжид хамрагдах эрхтэй гэж тусгасан. -Төсөлд Гэнэтийн аюулт үзэгдэл, эрсдэлт нөхцөлийн сөрөг нөлөөг бууруулах үйлчилгээний хүрээнд тэтгэмжийг урьдчилан олгох талаар тусгасан. Саналыг тусган амьжиргааны түвшинтэй уялдуулан үйлчилгээ үзүүлэхээр оруулсан.
8.	Дэлхийн зөн олон улсын байгууллага:	- Төсвийн аргачлал хөтөлбөр төрөл болж байна - Хөдөлмөрийн хуультай уях, албан бус хөдөлмөр эрхлэгч - Өрхийн орлогыг нэмэгдүүлэх дээр борлуулалтыг нэмэх юмыг томъёолж оруулах, эрэлт нийтүүлэлт дээр анхаарах - Стандарт хангуулах дээр анхаарах нэмүү өртгийн том зургаар өрхийн бизнесийг дэмжих хэрэгтэй	-Саналыг хүлээн авч хуулийн төсөлд заасан бие даан амьдрах чадавхыг дэмжих урт хугацааны үйлчилгээ болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх боломжтой.
2025.05.23 Яамдуудтай хийсэн хэлэлцүүлэг			
		- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1454 дугаар албан бичгээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авахаар бүх яамдад хүргүүлсэн. Яамдуудаас ирсэн төлөөлөл уг хуулийн төсөлд тусгах саналаа албан бичгээр ирүүлэхээр болов.	
2025.06.03-ны өдөр Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, төрийн бус байгууллага, холбоодод хийсэн хэлэлцүүлэг			

1.	Ахмадын холбооны гишүүн	- Ахмад настнуудыг ажилд авахгүй байна. - Жишээ нь: Нэг ахмад настан хөдөө туслах малчин хийх хүсэлтэй боловч та чадахгүй гээд ажиллуулахгүй байна. Уг нь тэр хүн чинь өөрөө чадахаас гадна туршлагатай байгаа юм. Тиймээс ахмад настныг ажил хийж орлого олох энэ дэмжлэг хэрэгтэй байна.	-Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн чадвартай, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй ахмад настны бүүртгэл мэдээллийн санг харьяа аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс бүрдүүлэн ажилд зуучлах арга хэмжээг авч ажиллаж байгаа. -Ахмад настны тухай хуульд энэ арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ нь тухайн жил
2.	Нийслэлийн хорооны дарга ахдмадын	- Халамжийн үйлчилгээг багасгах хэрэгтэй. Хуучин 1990 оны үед бол айлын хаалга тогшоод танайд дэмжлэг хэрэгтэй юу гэвэл үгүй манайх боломжтой гэж хариулдаг байлаа. Одоо бол эсрэгээрээ болсон. Боломжтой байсан ч боломжгүй гэж очиж бүртгүүлэх хүсэлтэй бэлэнчлэх сэтгэлгээтэй болж. Иймээс халамжийн үйлчилгээг зорилтот авах ёстой өрхөд нь хүргэх хэрэгтэй. Ингэснээр төсөв, мөнгө хэмнэгдэх боломжтой.	-Саналыг тусгав. Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд зорилтот бүлгийг оновчтой тодорхойлон халамжийн арга хэмжээнд хамруулах, амьжиргааны түвшний үнэлгээнд үндэслэн тэтгэвэр, тэтгэмж, дэмжлэгийг олгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтыг тусгасан. Зорилтот өрхийн хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх бодлогыг халамжийн хөтөлбөрүүдтэй уялдуулах, хүн капиталд хөрөнгө оруулах, үе дамжсан ядуурлаас сэргийлэх бодлого тусгасан.
3.	СХД-ийн ахмадын хорооны дарга	- Хууль хичнээн гарсан хэрэгжилт муу байх юм бол хуулийг хичнээн гоё сайхан болгож шинэчлээд нэмэргүй болно. Тиймээс хуулийн хэрэгжилтийг анхаараарай.	-Саналыг хүлээн авав.
4.	Ахмадын холбооны гишүүн	- Ахмад настан амралт сувилалд амрахад явдал чирэгдэл их байдаг. Зарим аймгууд өөр аймгийн ахмад настанг харьяалалын биш гээд амраадаггүй. Мөн хоолны асуудал хэцүү байна. Ахмад настан биеэ тэнхрүүлэх гэж амралт сувилалд амардаг боловч ногоо голдуу шөл, бантан өгдөг. Иймээс хоолны стандарттай болох хэрэгтэй.	-Саналыг тусгав. -Ахмадын амралт, сувилал, магадлан итгэмжлэгдсэн сувилалд хууль журмын дагуу ахмад настан харьяалал харгалзахгүй амарч, сувилуулах эрхтэй. Цаашид сувиллын хоол, үйлчилгээний чанарыг сайжруулахад Эрүүл мэндийн яаманд уламжлан ажиллах болно. Ахмадын зориулалттай амралт сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шалгуур

		Сувилгааны асуудлыг бас анхаарч, хяналт тавих хэрэгтэй.	болон хамтран ажиллах гэрээнд үйлчилгээний чанарын асуудлыг тусган хяналт тавьж ажиллаж байна.
5.	Ахмадын холбооны гишүүн	- Шинээр хууль журам боловсруулж байгаа бол шинэ нэр томьёо хэрэглэх хэрэгтэй. Ингэснээр хүмүүсийн анхаарлыг хандуулахаас гадна шинэ зүйл хэрэгжиж гэж байна гэж хүмүүс харна. Хуучин нэр томьёо хэрэглээд байхаар хүмүүс хуччин байдаг л нөгөө бодлого, шийдвэр хэрэгжиж байна гэж боддог. Шинэ халамжийн тухай хуулинд халамж гэдэг үгийг бага хэрэглэх хэрэгтэй.	-Саналыг судлан үзэх болно. -Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад олон улсын туршлагыг судалсан. Аливаа улс оронд нийгмийн халамжийн тусламж, нийгмийн халамж гэдэг нэр томьёо, тодорхойлолтууд байдаг бөгөөд тэдгээрт нийцүүлэн төслийг боловсруулсан.
6.	Ахмадын холбооны гишүүн	- Ахмад настнуудаар зуны цагт хүүхдийн зусланд ажиллуулах хэрэгтэй. Ахмадууд өөрсдөө хоолоо хийх, өөрсдөө ногоо цагаа тарих, ажил хийлгэж, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ чухал. Жишээ нь: Ахмадын хөдөлмөр зуслан гэж байсан.	-Ахмад настны тухай хуульд заасан ахмад настны хөгжлийг дэмжих үйлчилгээ, ахмад настны зөв хооллолт, эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ, сайн дурын үйлчилгээ, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх боломжтой.
7.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ-ын төлөөлөл	- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг авдаг сувиллын газар улсын хэмжээнд хэд байдаг вэ, бараг байхгүй гэж бодож байна.	-Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.7-д заасны дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд дотоодын магадлан итгэмжлэгдсэн 20 гаруй рашаан сувилалд сувилуулан хөнгөлөлт авч байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд сувиллын тоог нэмэгдүүлэх зорилгоор “рашаан” гэснийг хасч “магадлан итгэмжлэгдсэн сувилал” гэж өөрчлөн хүртээмжийг сайруулахаар тусгасан.
8.	Ахмадын холбооны гишүүн	- Хууль бодлогын баримт бичиг 2 өөр байх ёстой. Хууль бол илүү нийгмийн харилцааг зохицуулдаг. Гэвч энэ хуулиудыг судлахаар харилцааг зохицуулах гэхээс илүү үйл ажиллагааны шинжтэй болсон байна.	-Саналыг тусгав. -Нийгмийн халамжийн тухай хууль, түүнийг дагалдаж өөрчлөлт оруулах хуулийг төслийг Хууль тогтоомжийн тухай хууль болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан.

9.	Ахмадын холбооны гишүүн	- Иргэдийг аль болох бэлэнчлэх сэтгэлгээнээс салгах, халамжийг багасгаж, тодорхой зорилтот бүлэг буюу авах ёстой хүн нь халамж хүртдэг байх	-Саналыг тусган, хуулийн төслийг боловсруулахдаа хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах, халамжийн хамрах хүрээг оновчтой болгох, зорилтот бүлэгтээ чиглүүлэх зарчмыг баримталсан.
----	-------------------------	---	--

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ